



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2008 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 1/51

Мандалговь

“Бүрдийн уянга хүүхдийн зуслангийн дээврийн засвар”-ын
ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Бүрдийн уянга хүүхдийн зуслангийн дээврийн засвар”-ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Ц.Лхагвасүрэн (Сайнцагаан сумын Засаг Даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Ц.Эрдэнээ (Иргэний төлөөлөл)

Б.Гарамханд (Орон нутгийн өмчийн газрын өмч хариуцсан мэргэжилтэн)

Г.Оюунтунгалаг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн ажилтан)

Нарийн бичиг:

М.Бат-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн Газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ц.Лхагвасүрэн)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4822150111